



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Сайн туршлагыг сайжруулан
хэрэгжүүлэх тухай

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4, 18.3.10, Жендэрийн үндэсний хорооны дүрмийн 2.7-д заасныг үндэслэн Хорооны ээлжит хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиглэлээр үндэсний, салбарын, орон нутгийн түвшинд тулгамдаж буй асуудлаар жендэрийн арга зүйгээр дэмжсэн сайн туршлагыг гаргахад оруулж буй хувь нэмрийг үнэлж Архангай аймгийн Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Хүчирхийллийн эсрэг үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь салбар, Орхон аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төв, Сэлэнгэ аймгийн жендэрийн салбар хороо, Төв аймгийн Борнуур сумын засаг даргын тамгын газар, Увс аймгийн Бөхмөрөн сумын дунд сургууль, сайн туршлагыг хэрэгжүүлэхэд хамтран ажилласан аймгуудын Жендэрийн салбар хороо тус бүрт “Батламж” олгосугай.

2. Дээрх 6 аймгийн жендэрийн салбар хороо, холбогдох байгууллага нь жендэрийн тэгш байдлыг дэмжсэн сайн туршлагыг 2020 онд үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэхүйц түвшинд сайжруулан, хэрэгжүүлж ажилласугай.

3. Дараагийн шатны Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрт сайн туршлагыг тусган, түгээн дэлгэрүүлж ажиллахыг Хорооны ажлын албанд даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтийг 2021 оны ээлжит хуралдаанд тайлагнахыг Хорооны нарийн бичгийн дарга /Т.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА



У.ХҮРЭЛСҮХ